

Сүмийн түүхийг өөрсөдтэйгөө адилтгах

Үйл ажиллагаа А

САЙН МЭДЭЭГ НОМЛОХ

Бошиглогч Иосеф Смит: “Мөрдлөг хавчлага үнэний өсөлт хөгжилтийг зогсоож чадаагүй юм” (*History of the Church*, 4:540) гэж бичжээ. Их Эзэн өмнө нь Арван хоёр төлөөлөгчийн чуулгын олон гишүүнийг хилийн чанадад номлолд үйлчлүүлэхээр дуудаж байсан. Өвчин, зовлон бэрхшээлээ үл харгалзан эдгээр ах Наувугаас хилийн чанадад үйлчлэхээр явцгаажээ. Үүний үр дүнд, мянга мянган хүн, ялангуяа англичууд Бурханаас гэрчлэл хүлээн авч, Сүмд нэгдэж, Науву руу нүүж очив. Тэд Сүмд агуу хүч нь болсон.

1 Нифай 3:7, Сургаал ба Гэрээ 3:1-ийг уншаад, эдгээр шүлэг номлолын ажлын энэ жишээтэй хэрхэн холбогдож болохыг бодож үзээрэй.

Үйл ажиллагаа Б

ХАЛАМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙГ БАЙГУУЛСАН НЬ

Гэгээнтнүүдийг Наувугийн ариун сүмийг барьж байх үед ариун сүмд ажиллаж байсан олон эрэгтэйд хангалттай гутал, өмд, цамц дутмаг байгааг хэдэн эгч анзаарчээ. Тэд Их Эзэнд итгэж, хэсэг эмэгтэйг зохион байгуулж, эдгээр хувцсыг хангахаар хамтран ажиллаж эхэлсэн. Тухайн үеийн ижил төстэй бүлгүүдийн адилаар тэд үндсэн дүрмийг боловсруулан, уг бичгээ Иосеф Смитэд батлуулахаар танилцуулав.

Иосеф үүнийг [хараад], энэ төрлийн сайн үндсэн дүрэм болсон байна гэж хэлжээ. “Гэхдээ энэ нь та нарын хүссэн зүйл биш байна” гэснээ тэрээр: “Өргөлийг нь Их Эзэн хүлээн авсан бөгөөд Түүнд тэдэнд зориулсан өөр илүү чухал зүйл бий гэдгийг эгч нарт хэл. . . . Би эмэгтэйчүүдийг санваарын удирдлаган доор санваартнуудын жаягаар зохион байгуулна” гэж хэлжээ. (*Гэгээнтнүүд*, 1:448)

1842 оны 3-р сарын 17-нд Бурхан Иосеф Смитэд Халамжийн нийгэмлэгийг зохион байгуулахыг зааварласан. Бурхан өнөөдөр ч Халамжийн нийгэмлэгийн удирдагчдыг Сүмийн гишүүдэд төдийгүй тоо томшгүй олон хүнд үйлчилж, тэднийг хүчирхэгжүүлэхэд нь сүнслэгээр нөлөөлсөөр байна.

Сургаал ба Гэрээ 58:26–28-ыг уншиж, эдгээр шүлэг нь сүнслэг нөлөөгөөр Халамжийн нийгэмлэгийг байгуулсан эмэгтэйчүүдтэй хэрхэн холбогдож байгааг олж мэд.